

MORE STEP – Mobility at risk: Sustaining the Mongolian Steppe Ecosystem

Newsletter No. 9

www.morestep.org

April 2025

Societal change - Rural to Urban Migration in Mongolia

Editorial

Welcome to our ninth newsletter! MORE STEP is a collaborative and interdisciplinary research project implemented by Mongolian and German partners and funded by the German Federal Ministry of Education and Research.

Background

Since the 1990s, Mongolia's capital city Ulaanbaatar has recorded steady and rapid population growth due to rural-urban migration. So far, little is known about how the social and ecological conditions of migration interact. Thus, in our study we investigated the rural-urban migration process from the countryside to the capital in the Eastern Steppe conducting semi-structured interviews.

Results

Our results show that this rural-urban migration often follows a stepwise process from smaller settlements to larger urban areas. The results also demonstrate a complex interplay between the prevailing social, economic, and ecological factors. While social factors (kinship, education) show the same relevance at each step of migration, ecological factors such as the occurrence of Dzud seem more relevant at the early stages, from the steppe to the Soum centers. Ecological factors only seem to rank second in importance, after social reasons. Economic reasons are also revealed to be very significant but seem most relevant the closer the migrations are to the capital (see Fig.1).

These results are essential in order to cope with current and future challenges of population development and find solutions to enable traditional Mongolian nomadism even under a modern lifestyle.




Figure 1. Social-ecological conditions of the stepwise process of rural-urban migration in Mongolia, and the importance of social, economic and ecological circumstances per migration step.

Source: Mehring et al. 2017

In short

Analyzing data from herder households, we confirmed our hypothesis of step-wise migration, where herders generally move short distances, influenced by various ecological, social, and economic factors. Our findings indicate that herders do not strictly follow official pasture use regulations but instead rely on informal practices and social networks to adapt to changing conditions, highlighting the evolving nature of traditional nomadic pasture use.

For questions related to this topic please contact Dr. Marion Mehring at mehring@isoe.de

Publication: Tame, A., Batjav, B., Matias, D.M., Mehring, M. (2022). Rural to urban migration in Mongolia - Social-ecological conditions for a stepwise process. ISOE Discussion paper, 47, ISSN 1436-3534

Reference: Mehring, M., Bernard, B., Hummel, D., Liehr, S., Lux, A. (2017). Halting biodiversity loss: how social-ecological biodiversity research makes a difference. International Journal of Biodiversity Science, Ecosystem Services & Management 13 (1), 172–180

MORE STEP Мэдээллийн товхимол

**МОРЕ СТЭП – Нүүдэл шилжилт хөдөлгөөний эрсдэлд:
Тал хээрийн экосистемийн тогтвортой байдлыг хангах нь**

Товхимол №9

www.morestep.org

Дөрөвдүгээр сар, 2025

Нийгмийн өөрчлөлт - Орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн

Редакцийн зурвас


Бидний бэлтгэсэн ээлжит мэдээллийн товхимлыг хүлээн авна уу! МОРЕ СТЭП нь ХБНГУ-ын Засгийн Газрын Боловсрол, Судалгааны Яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол, Герман хоёр орны хамтран хэрэгжүүлж буй салбар хоорондын судалгааны төсөл юм.

Өмнөтгөл

1990-ээд оноос хойш Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хүн ам хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр тогтвортой, хурдацтайгаар нэмэгдэж байгаа билээ. Гэвч энэ шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх нийгэм болон экологийн төлөв байдал хэрхэн харилцан үйлчилж буй талаар өнөөг хүртэл хангалттай судлагдаагүй байна. Иймд бид Зүүн бүсийн аймаг, орон нутгаас төв суурин, цаашлаад нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөний явцыг хагас бүтэцчилсэн ярилцлагын аргаар судалсан.

Үр дүн

Судалгааны үр дүнгээс харахад хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн нь ихэвчлэн жижиг баг, сумын төвөөс эхлээд хүн ам ихтэй хот суурин газар хүртэл шаталсан байдлаар явагддаг байна. Эндээс зонхилох нийгэм, эдийн засаг, экологийн хүчин зүйлс хоорондын ярвигтай харилцан үйлчлэлийг ажиглаж болно. Нийгмийн хүчин зүйлс (ураг төрлийн холбоо, боловсрол... г.м) шилжилт хөдөлгөөний шат бүрт адил ач холбогдол ихтэй байдаг бол экологийн хүчин зүйлс (зудын аюул... г.м) нь малын бэлчээрээс сумын төв хүртэлх үе буюу шилжилт хөдөлгөөний эхний үе шатанд илүү чухал байдаг аж. Харин эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөгөөр шилжин суурьших үзэгдэл сууринаас суурин буюу аймгийн төвөөс хот руу шилжих үед илүү ач холбогдолтой байна. Энэ үр дүн нь хүн амын хөгжлийн өнөөгийн болон ирээдүйн сорилтуудыг даван туулах хийгээд орчин үеийн амьдралын хэв маягийн өөрчлөлтөд нийцсэн Монголын уламжлалт нүүдэлчин ахуйг бий болгох шийдлийг олоход нэн чухал.



Зураг 1. Орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөний шаталсан үйл явц ба түүнд нөлөөлөх эдийн засаг, нийгэм-экологийн хүчин зүйлсийн ач холбогдол
Эшлэл: Mehring et al. 2017

Товчоор

Малчин өрхөөс цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ бид малчид экологи, нийгэм, эдийн засгийн явз бүрийн хүчин зүйлсийн нөлөөгөөр үе шаттайгаар, богино зайд нүүдэллэдэг тухай таамаглалаа баталлаа. Уг үр дүн нэг талаар малчид бэлчээр ашиглалтын албан ёсны хууль журмыг чандлан мөрдөхөөс илүүтэй албан бус практик, нийгмийн хүрээлээ ашиглан өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицож байгааг; нөгөөтэйгүүр уламжлалт нүүдлийн бэлчээр ашиглалт хувьсан өөрчлөгдөж буйг харуулсан юм.

Дэлгэрэнгүй мэдээлэл: Др. Марион Мэрингтэй mehring@isoe.de хаягаар холбогдоно уу.

Эх сурвалж: Tarne, A., Batjav, B., Matias, D.M., Mehring, M., 2022. Rural to urban migration in Mongolia - Social-ecological conditions for a stepwise process. ISOE Discussion paper, 47, ISSN 1436-3534

Эшлэл: Mehring, Marion/Barbara Bernard/Diana Hummel/Stefan Liehr/Alexandra Lux (2017): Halting biodiversity loss: how social-ecological biodiversity research makes a difference. International Journal of Biodiversity Science, Ecosystem Services & Management 13 (1), 172-180